

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын  
2015 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн  
... тоот тушаалын гуравдугаар хавсралт

## СОЁЛЫН ӨВИЙН СУДАЛГАА ХИЙХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажил хийхэд энэ журмыг мөрдөнө.

1.2. Энэ журам нь палеонтологи, археологийн судалгааны ажлын чиглэл, хэлбэрээс үл хамааран байгууллага, иргэнд тэгш үйлчилнэ.

### Хоёр. Нэр томъёо

2.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

- 2.1.1. “**эрдэм шинжилгээний судалгаа**” гэж шинжлэх ухааны арга зүйн дагуу судалгааны тодорхой чиглэлээр шинэ болон нэмэлт мэдлэг бий болгох зорилготой гүйцэтгэх палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлыг;
- 2.1.2. “**авран хамгаалах судалгаа**” гэж байгаль орчны өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагаанд өртөн эвдэрч, устах эрсдэлд орсон дурсгалыг хамгаалах болон газрын хэвллийг ашиглахаас өмнө захиалагчийн хүсэлтийн дагуу гүйцэтгэх палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлыг;
- 2.1.3. “**хайгуул судалгаа**” гэж соёлын өвийг нээж илрүүлэх, бүртгэн баримтжуулах, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах зорилгоор хийх палеонтологи, археологийн судалгааны ажлын хэлбэрийг;
- 2.1.4. “**малтлага судалгаа**” гэж газрын хөрсөн доорхи геологийн хурдас, соёлт давхрагыг судалж танин мэдэх, олдвор, эд зүйл илрүүлэн судлах зорилгоор хийх палеонтологи, археологийн судалгааны ажлын хэлбэрийг;
- 2.1.5. “**мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага**” гэж Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-т заасан, палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийдэг хуулийн этгээдийг;
- 2.1.6. “**судалгааны анги**” гэж мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаас зохион байгуулах палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлыг гүйцэтгэх зохих хүний нөөц, багаж, техник, тоног төхөөрөмж бүхий бие даасан болон хамтарсан бүрэлдэхүүнийг;
- 2.1.7. “**мэргэжлийн судлаачдын баг**” гэж Иргэний хуулийг 481.1-д заасны дагуу гэрээ байгуулсан, энэ журмын 3.10-т заасан шаардлагыг хангасан 2 ба түүнээс дээш Монгол Улсын иргэдийн нэгдлийг;

- 2.1.8. “**мэргэжлийн зөвлөл**” гэж мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн судлаачдын багт палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажил хийх зөвшөөрөл олгох эсэх, судалгааны явцыг хянах, соёлын биет өвийг хамгаалах талаар санал боловсруулж Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд зөвлөх үүрэг бүхий орон тооны бус нэгжийг;
- 2.1.9. “**зөвшөөрөл**” гэж мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага болон мэргэжлийн судлаачдын багт олгох баримт бичгийг;
- 2.1.10. “**олдвор**” гэж палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны үр дүнд илэрч олдсон чулуужсан үлдэгдэл, эд зүйлс, тэдгээрийг илэрхийлэх боломжтой нэгдмэл болон салангид биет үнэт зүйлсийг;
- 2.1.11. “**судалгааны дээж**” гэж палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны үр дүнд илэрч олдсон бие даан эд зүйл илэрхийлэх боломжгүй хэсэг, эсвэл олдворын эд зүйл илэрхийлэх шинж чанарыг алдагдуулахгүй дээжлэн авсан хэсгийг.

**Гурав. Палеонтологи, археологийн хайгуул,  
малтлага судалгааны ажил хийх байгууллага**

3.1. Палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлыг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага /цаашид “эрдэм шинжилгээний байгууллага” гэх/ эрхлэн явуулна.

3.2. Эрдэм шинжилгээний байгууллага нь палеонтологи, археологийн судалгааны ажлын зорилго, чиглэл, хүрэх үр дүн бүхий ойрын, дунд, хэтийн бодлого төлөвлөлттэй, мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй, олдвор, эд зүйлсийг хадгалах сан хөмрөгтэй, сэргээн засварлах багаж, техник, тоног төхөөрөмж бүхий лабораторитой байна.

3.3. Эрдэм шинжилгээний байгууллага нь хамтран ажиллах гэрээний үндсэн дээр гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажил хийж болно.

3.4. Эрдэм шинжилгээний байгууллага нь төрийн тахилгат болон уламжлалт хориг бүхий газарт палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажил хийх бол энэ тухай Мэргэжлийн зөвлөлд судалгаа хийхээс 6 сараас багагүй хугацааны өмнө бичгээр мэдэгдэнэ.

3.5. Энэ журмын 3.4-д заасан судалгааны ажлыг Мэргэжлийн зөвлөлд танилцуулж зохих зөвлөмж гаргуулалгүй гадаадын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулахыг хориглоно.

3.6. Эрдэм шинжилгээний байгууллага нь гадаадын иргэн, харьялалгүй хүнтэй Монгол Улсын нутаг дэвсгэр дээр палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажил хийхээр гэрээ байгуулах, судалгаа хийхийг хориглоно.

3.7. Эрдэм шинжилгээний байгууллага нь хамтарсан болон бие даасан судалгааны ангийг удирдан зохион байгуулах үүрэг бүхий удирдагч, судалгааны ангийг өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг бүхий эрдэм шинжилгээний ахлагчийг томилно. Удирдагч нь тухайн байгууллагын орон тооны ажилтан, уг салбарт 10-аас доошгүй жил ажилласан, палеонтологи, түүх, археологийн чиглэлээр докторын зэрэг хамгаалсан Монгол Улсын иргэн, эрдэм шинжилгээний ахлагч нь тухайн байгууллагын орон тооны ажилтан, уг салбарт 5-аас доошгүй жил ажилласан, палеонтологи, археологийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн, магистраас дээш зэрэгтэй Монгол Улсын иргэн байна.

3.8. Эрдэм шинжилгээний байгууллага нь судалгааны ажлын үр дүнд олдсон олдворыг бүртгэх, судлах, найдвартай орчинд хадгалах, сэргээн засварлах асуудлыг тухайн төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулна.

3.9. Эрдэм шинжилгээний байгууллага нь судалгааны ажлын явц, гүйцэтгэл, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд тухайн судалгааны ангийн нийт төсвийн 1 хүртэл хувийг зарцуулна.

3.10. Палеонтологи, археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлыг мэргэжлийн судлаачдын баг /цаашид "судлаачдын баг" гэх/ энэ журмын 4.1-т заасан зөвшөөрлийн дагуу хийж болно.

3.11. Судлаачдын баг нь дор дурдсан шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 3.11.1. хамtran ажиллах гэрээний үндсэн дээр зохион байгуулагдсан байх;
- 3.11.2. багийг төлөөлөх удирдагчтай байх;
- 3.11.3. гишүүдийн 50-иас доошгүй хувь нь палеонтологи, түүх, археологийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн байх;
- 3.11.4. гишүүн нь Соёлын болон шинжлэх ухааны холбогдолтой хууль тогтоомжийг зөрчиж захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх;
- 3.11.5. палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлыг хийх санхүүгийн болон багаж, техник тоног төхөөрөмж бүхий чадавхитай байх.

3.12. Судлаачдын багийг төлөөлөх удирдагч нь уг салбарт 10-аас доошгүй жил ажилласан, палеонтологи, түүх, археологийн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан Монгол Улсын иргэн байна.

3.13. Судлаачдын баг нь санхүүгийн болон багаж, техник, тоног төхөөрөмжийн чадавхия нэмэгдүүлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байж болно.

## **Дөрөв. Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын зөвшөөрөл олгох**

4.1. Палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний хайгуул, малтлага судалгааны ажлын зөвшөөрлийг эрдэм шинжилгээний байгууллагаас зохион байгуулах судалгааны анги тус бүрт, авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлын зөвшөөрлийг эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын багт олгоно.

4.2. Эрдэм шинжилгээний байгууллага нь жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор тухайн жилд зохион байгуулах палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний хайгуул, малтлага судалгааны ангийн жагсаалтыг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хүснэгтийн дагуу гаргаж зөвшөөрөл хүссэн албан бичгийн хамт Мэргэжлийн зөвлөлд хүргүүлнэ.

4.3. Зөвшөөрөл хүссэн албан бичигт дор дурдсан баримтыг судалгааны анги тус бүрээр гаргаж хавсаргана. Үүнд:

- 4.3.1. байгууллагын эрх бүхий албан тушаалтны баталсан судалгааны ангийн удирдамж, календарчилсан төлөвлөгөө;
- 4.3.2. хайгуул, малтлага судалгааны ажилд хамрагдах газар нутаг, дурсгалыг 1:100.000 зурагт байршуулсан тэмдэглэл;
- 4.3.3. судалгааны ангийн санхүүжилтийн талаарх мэдээлэл;
- 4.3.4. судалгааны ангийн бүрэлдэхүүнд орох судлаачдын нэрс, багаж, техник, тоног төхөөрөмжийн жагсаалт;
- 4.3.5. гадаадын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтарсан судалгааны анги бол хамтран ажиллахаар байгуулсан гэрээний хуулбар, судалгааны ангид оролцох гадаадын судлаачдын мэдээлэл.

4.4. Эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын баг нь жил бүрийн 03 дугаар сарын 10-ны дотор тухайн жилд хийх палеонтологи, археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлын зөвшөөрөл хүссэн албан бичгээ /судлаачдын багийн хувьд өргөдөл байх/ Мэргэжлийн зөвлөлд ирүүлнэ.

4.5. Зөвшөөрөл хүссэн албан бичиг, өргөдөлд дор дурдсан баримтыг хавсаргана. Үүнд:

- 4.5.1. палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын туршлагын талаарх мэдээлэл;
- 4.5.2. санхүүгийн болон багаж, техник, тоног төхөөрөмж бүхий чадавхитай болохыг илэрхийлсэн баримт;
- 4.5.3. мэргэжлийн зөвлөлөөс шаардсан бусад баримт.

4.6. Мэргэжлийн зөвлөл энэ журмын 4.2, 4.4-т заасан хүсэлтийг хурлаараа хэлэлцэж зөвшөөрөл олгох эсэх талаар гаргасан саналаа Соёлын асуудал асуудаа эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж шийдвэр гаргуулна.

4.7. Мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга энэ журмын 4.6-д заасан шийдвэрийг үндэслэн судалгааны чиглэлийн дагуу энэ журмын 2 дугаар хавсралтад заасан загвар бүхий зөвшөөрлийг Мэргэжлийн зөвлөлийн даргаар гарын үсэг зуруулж баталгаажуулан олгоно. Зөвшөөрөлд дор дурдсан бичвэрийг бичнэ. Үүнд:

4.7.1. судалгааны ангид тухайн оны төгсгөлийн 2 орон, эрдэм шинжилгээний байгууллагын тушаалын хавсралтад байршсан дугаар, тухайн судалгааны ангийн хүснэгтэд байрласан дугаар бүхий тусгай дугаар өгч палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний хайгуул, малтлага судалгааны ажил хийх зөвшөөрөл олгоно. /Дугаарын жишээ 15-2-1 гм/ Зөвшөөрөл судалгааны ангийн нэр, удирдагчийн нэр, судалгааны ажил хийх засаг захираганы нэгжийн нэр, судалгаанд хамрагдах газар нутгийн нэр, дурсгалын нэр, судалгааны ажлын эхлэх дуусах хугацааг бичнэ.

4.7.2. эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын багт тухайн оны төгсгөлийн 2 орон, эрдэм шинжилгээний байгууллагын тушаалын хавсралтад байршсан дугаар бүхий тусгай дугаар өгч палеонтологи, археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажил хийх зөвшөөрөл олгоно. /Дугаарын жишээ 15-1 гм/ Зөвшөөрөл эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын багийн нэр, удирдагчийн нэр, судалгааны ажлын хэлбэр, эхлэх дуусах хугацааг бичнэ.

4.8. Мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга зөвшөөрөл олгосон шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан аймаг, нийслэлийн Засаг даргад нутаг дэвсгэрт нь палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажил хийх судалгааны ангийн талаарх мэдээллийг хүргүүлнэ.

4.9. Зөвшөөрлийг бусад этгээдэд дамжуулан ашиглуулах, барьцаалахыг хориглоно.

4.10. Монгол Улсад бүртгэлтэй аль нэг эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулаагүй гадаадын эрдэм шинжилгээний байгууллагад палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажил хийх зөвшөөрөл олгохгүй.

4.11. Нэг жил тухайн судалгааны газарт хоёр ба түүнээс дээш эрдэм шинжилгээний байгууллагаас палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажил хийх зөвшөөрөл хүссэн тохиолдолд өмнө нь судалгаа хийсэн эрдэм шинжилгээний байгууллагын саналыг хүндэтгэн үзнэ.

4.12. Эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын баг нь Улсын тусгай хэрэгцээний газарт палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажил хийхдээ холбогдох байгууллагаас хууль тогтоомжид заасан зөвшөөрөл авна.

Тав. Эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын

## багт олгосон зөвшөөрөлд өөрчлөлт оруулах

5.1. Эрдэм шинжилгээний байгууллага энэ журмын 4.6-д заасан шийдвэрээр зөвшөөрөл олгосон газар нутагт эрх бүхий байгууллагын шийдвэрээр хорио цээрийн дэглэм тогтоосон, судалгааны ажлын явцад гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн бол зөвшөөрөлд бичигдсэн засаг захиргааны нэгжийн нэр, судалгаанд хамрагдах газар нутгийн нэр, дурсгалын нэр, эхлэх дуусах хугацаанд өөрчлөлт оруулах хүсэлтийг Мэргэжлийн зөвлөлд гаргаж болно.

5.2. Мэргэжлийн зөвлөл хүсэлтийг хурлаараа хэлэлцэж, зөвшөөрлийн хугацаанд өөрчлөлт оруулах эсэх талаар гаргасан саналаа Соёлын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнд танилцуулж шийдвэр гаргуулна.

5.3. Мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга энэ журмын 5.2-т заасан шийдвэрийг гарсан даруйд нь харьялах аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

5.4. Энэ журмын 5.2-т заасан шийдвэрээр зөвшөөрлийн хугацаанд оруулсан өөрчлөлт нь энэ журмын 6.2-т заасан хугацаатай нийцсэн байна.

### **Зургаа. Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажил явуулах.**

6.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажил хийхээр зөвшөөрөл авсан Эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын баг нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Улсын хилийн тухай, Шинжлэх ухаан технологийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг чанд мөрдөж ажиллана.

6.2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлыг жил бүрийн 04 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 01-ний хүртэлх хугацаанд зохион байгуулна.

6.3. Эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын баг нь палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлыг зохион байгуулахдаа дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 6.3.1. судлаачийн амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;
- 6.3.2. судалгаа эхлэхээс өмнө харьялах сум, дүүргийн Засаг даргад газар нутагт нь палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажил хийх талаар урьдчилан мэдэгдэх;
- 6.3.3. нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн ард иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг

хүндэтгэж судалгаатай холбогдолтой мэдээллээр хангах, судалгааны үр дүнг сурталчилах;

6.3.4. палеонтологи, археологийн малтлага судалгааны ажлын явцыг гадаад дотоодын жуулчдад нээлттэй танилцуулах.

6.4. Эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын баг нь палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажил хийх явцдаа олж илрүүлсэн соёлын биет өвийг цаашид нарийвчлан судлах тохиолдолд давуу эрх эдэлнэ.

6.5. Эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын баг нь Палеонтологи, археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгаа хийх зөвшөөрөл авсан судалгааны ажил хийлгэхээр хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах гэрээг заавал байгуулна.

6.6. Эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын баг нь палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажил хийх явцад түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн хувьд өндөр ач холбогдолтой дурсгалт зүйл, дурсгалт газар илэрсэн бол цаашид үргэлжлүүлэн судлах, хадгалж хамгаалах саналаа нэн даруй Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

6.7. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 6.5-д заасан саналыг хүлээн авсны дараа илэрсэн олдвор, эд зүйл, дурсгалын аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох мэргэжилтнээс бүрдсэн судалгааны нэмэлт багийг томилон ажиллуулж болно.

6.8. Судалгааны анги судлаачдын баг нь палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлыг зохион байгуулахдаа дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 6.8.1. судалгааны ажил эхлэхээс өмнө харьялах сум дүүргийн Засаг даргад судалгааны ажлын зорилго, чиглэл, хэлбэр, судалгааны ангийн бүрэлдэхүүний талаар танилцуулах;
- 6.8.2. судалгаанд хамрагдаж буй дурсгалд эрх бүхий байгууллагаас хамгаалалтын бүс тогтоосон бол судалгааны хотхоныг хамгаалалтын бүсийн гадна байгуулах;
- 6.8.3. орон нутгийн ард иргэдэд судалгааны ач холбогдлыг ойлгуулах, судалгааны ажлын талбайг танилцуулах;
- 6.8.4. Улсын тусгай хэрэгцээний газарт судалгаа хийх бол холбогдох хууль тогтоомжид заасан дэглэмийг мөрдөх;
- 6.8.5. судалгааны явцад илэрч олдсон олдвор, эд зүйлсийг аюулгүй орчинд хадгалах;
- 6.8.6. судалгааны ажил дууссаны дараа уг газрыг аюулгүй болгон сум орон нутгийн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгч, зөвшөөрөлд тэмдэглүүлэх.

6.9. Судалгааны анги нь палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлыг зохион байгуулахдаа дараах эрх эдлэнэ.

- 6.9.1. палеонтологи, археологийн шинжлэх ухааны арга зүйг чөлөөтэй сонгож, судалгаанд шаардлагатай багаж, техник, тоног төхөөрөмжийг ашиглах;
- 6.9.2. сум, дүүргийн холбогдох байгууллагаас судалгааны ажилд зориулан дэмжлэг авах;
- 6.9.3. судалгаанаас гарсан үр дүнг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, эзэмших;
- 6.9.4. судалгааны үр дүнг олон нийтэд мэдээлэх, сурталчилах, эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэх;

6.10. Эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын баг нь палеонтологи, археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгаа хийхдээ энэ журмын 6.8-д заасан үүргийг гүйцэтгэж, 6.9-д заасан эрхийг эдэлнэ.

6.11. Судалгааны анги малтлагын ажлыг тодорхой хугацааны дараа үргэлжлүүлэн судлах зорилгоор малтлагын талбайг харуул хамгаалалттайгаар үлдээж болно. Энэ тухай Мэргэжлийн зөвлөл, харьялах Засаг даргад мэдэгдэнэ.

#### **Долоо. Судалгааны дээжийг лабораторид судлуулах**

7.1. Эрдэм шинжилгээний байгууллага болон судлаачдын баг нь палеонтологи, археологийн судалгааны дээжийг гадаад, дотоодын лабораторид судлуулж болно.

7.2. Судалгааны дээжийг хилээр нэвтрүүлэх асуудлыг Түүх, соёлын дурсгалт зүйлийг Улсын хилээр нэвтрүүлэх журмын дагуу зохицуулна.

7.3. Соёлын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай тохиолдолд судалгааны дээжийг гадаадын лабораторид илгээх асуудлыг Палеонтологи, археологийн мэргэжлийн зөвлөлд танилцуулж дүгнэлт гаргуулж болно.

#### **Найм. Судалгааны ажлын үр дүнг тайлагнах**

8.1. Эрдэм шинжилгээний байгууллага нь тухайн жилд зохион байгуулсан палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ангийн гүйцэтгэсэн ажлын тайланг, судлаачдын баг нь тухайн жилд гүйцэтгэсэн палеонтологи, археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлын тайланг энэ журмын 8.2-т заасан шаардлагад нийцүүлэн бичиж цаасан болон цахим хэлбэрээр дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор Мэргэжлийн зөвлөлд хүргүүлнэ.

8.2. Тайлан нь дараах шаардлагад нийцсэн байвал зохино. Үүнд:

- 8.2.1. тайлангийн бичвэр орчин цагийн монгол хэлний найруулга зүйд нийцсэн, техникийн алдаагүй, монгол хэлээр, кирилл үсгээр бичигдсэн байх;
- 8.2.2. судалгааны ажлын явц, үр дүнг бүрэн илэрхийлсэн бичвэр, гар зураг, гэрэл зурагтай байх;
- 8.2.3. судалгааны үр дүнгийн талаарх шинжлэх ухааны урьдчилсан дүгнэлттэй байх;
- 8.2.4. гэрээ, удирдамж, болон судалгаанд зарцуулсан зардлын задаргааг хавсаргах;
- 8.2.5. гадаад хэл дээрх холбогдох баримтын монгол орчуулгыг хавсаргах;
- 8.2.6. судалгаа хийсэн дурсгалт газар болон олдвор эд зүйлсийг хадгалж хамгаалах санал;
- 8.2.7. тайланд судалгааны явцад олж илрүүлсэн олдвор, эд зүйлсийн хийгдсэн материал, хэмжээ, жин, зориулалт, төрх байдлыг илэрхийлсэн жагсаалтыг хавсаргах;
- 8.2.8. олдвор, эд зүйлсийн шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг хавсаргах;
- 8.2.9. судалгааны явцад илрүүлсэн дурсгалын солбицол бүхий жагсаалтыг хавсаргах; /Солбицлыг UTM системээр тогтоох/
- 8.2.10. тайланг бичсэн эрдэмтэн, судлаачдаар гарын үсэг зуруулж баталгаажуулсан байх.

8.3. Мэргэжлийн зөвлөл 8.2-т заасан шаардлага хангасан тайланг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч тухайн жилийн судалгааны ажлын талаар нэгдсэн дүгнэлт гаргана.

8.4. Тайланг судалгааны ажлын нэгдсэн дүгнэлт гаргаснаас хойш ажлын 5 хоногт багтаан Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээлгэн өгч хадгалуулна.

8.5. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалж буй тайланд нэмэлт оруулах, засвар хийх бол тайланд гарын үсэг зурсан эрдэмтэн, судлаачийн гарын үсгээр баталгаажсан санал, байгууллагын албан бичиг, засвар оруулах бичвэрийн хамт Мэргэжлийн зөвлөлд ирүүлнэ.

8.6. Тайлан болон бусад материалыг хууль, тогтоомжид заасан нөхцлөөр иргэн, хуулийн этгээдэд ашиглуулж болно.

8.7. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлын явц, хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, дүгнэлт гаргуулах зорилгоор Ажлын хэсэг томилон ажиллуулж болно.

.....ОНД ПАЛЕОНТОЛОГИ, АРХЕОЛОГИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАЙГУУЛ, МАЛТЛАГА СУДАЛГАА ХИЙХ ЗӨВШӨӨРӨЛ ХУССЭН СУДАЛГААНЫ АНГИЙН ЖАГСААЛТ

БАСУУЛЛАСЫН НЭД

Соёлын ёвийн судалгаа хийх журмын  
хоёрдугаар хавсралт

ТУСГАИ ТЭМДЭГЛЭЛ

МОНГОЛ УЛС

БОЛОВСРОЛ, СОЕЛ, ШИНЖЛЭХ

УХААНЫ ЯАМ

ПАЛЕОНТОЛОГИ, АРХЕОЛОГИЙН  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАЙГУУЛ,  
МАЛТЛАГА СУДАЛГААНЫ АЖИЛ ХИХ  
**ЗӨВШӨӨРӨЛ**

ТЭМДЭГЛЭЛ БИЧСЭН:

/элбан тушаалын нэр/

/гарын усэг/

/нэрийн тайлал/

/тэмдэг/

Улаанбаатар хот

2015 оны .... сарын .....-ны өдөр

2015 он

№ .....

БОЛОВСРОЛ, СОЕЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САИДЫН  
2015 ОНЫ ..... ДУГААР САРЫН .....-НЫ  
ӨДРИЙН ..... ТООТТИШААЛААР .....  
..... -ИИН

..... УДИРДАГЧТАЙ

СУДАЛГААНЫ АНГИД  
ПАЛЕОНТОЛОГИ, АРХЕОЛОГИИН ЭРДЭМ  
ШИНЮКИЛГЭЭНИЙ ХАЙГУУЛ, МАЛТЛАГА СУДАЛГААНЫ  
АЖИЛ ХИХ ЗӨВШЕЕРӨЛ ОЛГОВ.

ЗӨВШЕЕРӨЛ ОЛГОСОН:

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

/зарын усээ/

/нэрийн тайлэл/

/тэмдээг/

2015 ОНЫ .... САРЫН .....-НЫ ӨДЕР

СУДАЛГААНЫ АЖИЛ ХИХ:

Засаг зэхиргэвэны наслжийн нэр: .....

Газар нутгийн нэр: .....

Дурголалын нэр: .....

Солбицол: .....

Хугацаа:

20..... оны ..... дугаар сарын .....-ны өдөр

20..... оны ..... дугаар сарын .....-ны өдөр

Энэхүү зөвшөөрөл нь зөвхөн зөвшөөрөлд бичигдсан  
гаазар, хугацаанд хүчинтэй.

ТУСГАИ ТЭМДЭГЛЭЛ

МОНГОЛ УЛС  
БОЛОВСРОЛ, СОӨЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ ЯАМ

ПАЛЕОНТОЛОГИ, АРХЕОЛОГИЙН  
АВРАН ХАМГААЛАХ ХАЙГУУЛ,  
МАЛТЛАГА СУДАЛГААНЫ АЖИЛ ХИХ  
**ЗӨВШӨӨРӨЛ**

ТЭМДЭГЛЭЛ БИЧСЕН:

/албан тушаалын нэр/

/зарын үсэг/

/нэрийн тайлал/

/тэмдэг/

2015 оны ..... сарын .....-ны өдөр

Улаанбаатар хот

2015 он

№ .....

СУДАЛГААНЫ АЖИЛ ХИХ:

БОЛОВСРОЛ, СОЕЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН  
2015 ОНЫ ..... ДУГААР САРЫН .....-НЫ  
ӨДРИИН ..... ТООТТУШААЛААР.....

.....-Д  
МОНГОЛ УЛСЫН НУТАГТ ДЭВСГЭРТ  
ПАЛЕОНТОЛОГИ, АРХЕОЛОГИИН АВРАН  
ХАМГААЛАХ ХАИГУУЛ, МАЛТЛАГА СУДАЛГААНЫ  
АЖИЛ ХИХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОВ.

Энэхүү зөвшөөрөл нь зөвхөн палеонтологи,  
археологийн авран хамгаалах хайгуул, малтлагав  
судалгааны ажил хийж буй газарт зөвшөөрөлд  
бичигдсэн хувацаанд хүчинтэй.

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН:

МЭРГЭЖЛИИН ЗӨВЛӨЛИИН ДАРГА

.....  
/зарын усээ/  
/нэрийн тайлал/  
/тэмдээ/

2015 оны .... сарын .....-ны өдөр